



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 1/329

Номгон

Г Түргэн хоолны үйлдвэрлэл үйлчилгээ Г  
эрхлэгчдэд хяналт тавих ажлын хэсэг  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн спортын VII их наадмын үеэр түргэн хоолны үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д. Ууганцэцэг Баянхонгор сумын Засаг даргын орлогч

Гишүүд:

Ч. Жавзандулам Хүнс хөдөө аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч

Д. Баасанцэрэн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

Г. Золбоо Хүнс, хөдөө аж ахуйн газрын Ургамал хорио цээрийн хяналтын улсын байцаагч

С. Сайнхүү Хүнс хөдөө аж ахуйн газрын Хүнс, худалдаа хариуцсан мэргэжилтэн

Б. Гүндсамба Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний үүргийн түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

Б. Ууганзаяа Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан Мэргэжилтэн

2. Түргэн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт тавьж, тайланг танилцуулахыг ажлын хэсэг (Д. Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

642310837

2.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-д даалгасугай.

